

**АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
ЗАХИРГААНААС ТУС УЛСЫН ЛАС ВЕГАС ХОТОД ЗОХИОН БАЙГУУЛСАН “ОЛОН УЛСЫН
СУРГАЛТЫН СИМПОЗИУМ”-Д ОРОЛЦСОН ТАЙЛАН**

2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр

Америкийн Нэгдсэн Улсын Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаанаас АНУ-ын Лас Вегас хотод 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрүүдэд зохион байгуулсан “Олон улсын сургалтын Симпозиум”-д дараах бүрэлдэхүүнтэй оролцлоо.

- Г.Мөнхболд НААХЗА-ны Аэродром, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын ахлах байцаагч;
- Б.Анхбаяр НААХЗА-ны Аэродром, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн нисэхийн аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч.

Олон улсын сургалтын симпозиум нь дараах хөтөлбөртэй зохион байгуулагдсан, үүнд:

1/ 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

- Олон улсын сургалтын тогтвортой байдал;
- Ажилд авах үйл явц/ Тогтвортой ажиллуулах бодлого;
- Сургалтын эх үүсвэр;
- Үр ашиг, үр дүнтэй байдлыг тэнцвэржүүлэх;
- Хэрэгцээ, төсөвт тулгуурлан сургалтын соёлыг өөрчлөх;
- Сургалтын олон улсын хамтын нийгэмлэгийн шилдэг туршлага;
- Кибер аюулгүй байдлын талаарх панел хэлэлцүүлэг.

2/ 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

- Нисгэгчгүй агаарын хөлгийн систем;
- Эрсдэлийн удирдлагын сургалт / эрсдэлийг ойлгох ба удирдах/;
- Дотоод заналхийлэл;
- Сургалтаа дамжуулж нисэхийн аюулгүй байдлыг сайжруулах;
- Агаараас эсэргүүцэн хамгаалах зөөврийн систем;
- Тээврийн аюулгүй байдлын ажилтны сургалт, аюулгүйн үзлэгийн ажилтны үнэмлэхжүүлэлт /анхан шат, давтан болон мэргэшүүлэх сургалт/;
- Зааварлагчийг хөгжүүлэх, үнэмлэхжүүлэх үйл явц;
- Зайнаас сургалт зохион байгуулах;
- Үйлчлүүлэгчийн туршлага/судалгаа.

3/ 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

- Лас Вегас хотын Харри Рэйд олон улсын нисэх буудал дахь Дэвшилтэт аюулгүйн үзлэгийн цэг- Өөртөө үйлчлэх аюулгүйн үзлэгийн цэгтэй танилцах аялал;
- Үр дүнтэй аюулгүй байдлын соёлыг бий болгох, хадгалах;
- Нисэх буудлын хамтын ажиллагааны хөтөлбөр;
- Удирдлагын хөгжлийн хөтөлбөр;
- Нийцлийн сургалт/ байцаагч нарын сургалт;
- Тусгай сургалттай танилцах аялал.

2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

- Олон улсын сургалтын тогтвортой байдлын талаарх панел хэлэлцүүлэг

Панел хэлэлцүүлэгт Германы Дотоод хэргийн яам, Латин ба Карибын тэнгисийн АНУ-ын Худалдаа, хөгжлийн агентлаг, Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргааны Олон улсын үйл ажиллагааны хэлтэс, Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргааны Аж ахуйн нэгжийн дэмжлэг хэлтэс болон Европын холбооны иргэний нисэхийн байгууллагын төлөөлөл тус тус оролцож аюулгүйн үзлэгийн ажилтнуудыг ажилд авах, тухайн ажлын байранд тогтвортой ажиллуулах, хэрэгцээнд тулгуурлан сургалт, кибер аюулгүй байдлын хяналт шалгалт, далд сорилт зэргийг тогтоох, тээш, ачааны аюулгүйн үзлэгийг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлэх, зохих ажилтнуудын цалин, хангамжийн талаар хэлэлцүүлэг хийсэн болно.

- Сургалтын олон улсын хамтын нийгэмлэгийн шилдэг туршлагын талаарх панел хүлэлцүүлэг

Канад Улсын Агаарын тээврийн аюулгүй байдлын газар /CATSA/, Хонг Конгын Нисэхийн аюулгүй байдлын компани /AVSECO/, Этиопын агаарын тээвэрлэгч, Кени Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар, Бразил Улсын Иргэний нисэхийн ерөнхий газрын төлөөлөгч нар тус тус оролцож Канад Улсын Сургалт болон Үнэмлэхжүүлэлтийн Үндэсний хөтөлбөр, Хонг Конгын Нисэхийн аюулгүй байдлын компани тэсэрч дэлбэрэх бодис илрүүлэх үнэрч нохойны сургалт, ашиглалт, Кенийн Иргэний нисэхийн ерөнхий газар Агаараас эсэргүүцэн хамгаалах зөөврийн системийн үнэлгээ, сургалт, Этиопын агаарын тээвэрлэгч иргэний нисэх дэх дотоод заналхийлэл, түүний эсрэг авах хариу арга хэмжээ, Бразилын Иргэний нисэхийн ерөнхий газраас хүний нөөц, сургалт, тэдгээртэй холбоотой эрсдэлийн дүн шинжилгээ зэрэг асуудлаар танилцуулга хийж, хэлэлцүүлэг явуулсан.

- Кибер аюулгүй байдлын талаарх панел хэлэлцүүлэг

Энэхүү хэлэлцүүлэгт Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргааны Нисэхийн кибер санаачилгын хэлтэс, Embry Riddle их сургууль, Холбооны нисэхийн захиргаа, Southwest агаарын тээвэрлэгч, Aerospace village байгууллагын төлөөлөгч нар кибер аюулгүй байдлын хэлэлцүүлэгт оролцож кибер аюулгүй байдлын сургалтын төрөл, гэрчилгээжүүлэлт, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан Кибер аюулгүй байдлын заавар, сургалт, сорилтын талаар мэдээлэл өгч, хэлэлцүүлэг хийсэн.

- 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Нисгэгчгүй агаарын хөлгийн систем, Агаараас эсэргүүцэн хамгаалах зөөврийн систем, Эрсдэлийн удирдлагын сургалт / эрсдэлийг ойлгох ба удирдах/, Дотоод заналхийлэл зэрэг асуудлын талаарх танилцуулга хэлэлцүүлгийг Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргааны Холбооны Агаарын Маршлын хэлтсийн ажилтнууд хийсэн ба 250 граммаас дээш жинтэй дроныг 107 дугаар дүрмийн дагуу Холбооны нисэхийн захиргаанд бүртгүүлдэг бөгөөд дронтой холбоотой зайны сургалтыг тус захиргааны албан ёсны хуудсанд байршуулсан байна.

Агаараас эсэргүүцэн хамгаалах зөөврийн системийн Үндэсний хөтөлбөртэй ба уг хөтөлбөрийн дагуу суурь сургалт зохион байгуулах, зааварлагчийн хөтөлбөр боловсруулах, нисэх буудлын гадна байршлыг тогтоох зэрэгт туслалцаа үзүүлэх зэрэг ажлыг зохион байгуулдаг байна.

Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын талаарх ойлголт өгч, тус нэгж нь Эрсдэлийн үнэлгээний семинар, Дотоод эрсдэлийн семинар, Зан байдлаар таних семинар болон Сонгон, тааварлашгүй байдлаар аюулгүйн үзлэг хийх сургалтуудыг тус тус явуулдаг талаар танилцуулга хийсэн.

- **Тээврийн аюулгүй байдлын ажилтан /TSO/-ы сургалт, аюулгүйн үзлэгийн ажилтны үнэмлэхжүүлэлт /анхан шат, давтан болон мэргэшүүлэх сургалт/**

Тээврийн аюулгүй байдлын ажилтныг анхан шат, давтан болон мэргэшүүлэх сургалтуудад хамруулдаг ба жилийн туршид давтан сургалтыг хийж, мэргэжлийн сорилтуудыг зохион байгуулдаг.

Анхан шатны сургалт нь дараах бүрэлдэхүүнтэй, үүнд:

1. эхний нэг долоо хоногт Ерөнхий урьдчилан танилцах сургалт,
2. нисэх буудал дээр хийх дөрвөн долоо хоногийн сургалт, ажлын байран дээрх сургалт,
3. Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргааны Сургалтын академийн сургалт болон нисэх буудал дахь ажлын байран дээрх сургалт.

Нисэх буудал дээр хийгдэх 4 долоо хоногийн сургалт нь аюулгүйн үзлэгийн цэг дээрх сургалт болон танхим, тренажёр болон ажлын байран дээрх сургалтаас тус тус бүрдэнэ. Ажлын байран дээрх сургалт 10 цаг үргэлжилнэ.

Анхан шатны сургалтын 2 дугаар үе шат нь тухайн нисэх буудал дахь зааварлагчийн удирдлага доор явагдах ба ажилтны ажилд томилсны дараа ажлын байран дээрх сургалтад хамрагдах ба энэ сургалт 16 цаг үргэлжилнэ. Ажлын байран дээрх сургалтын дараа дүрс дүгнэх шалгалт өгдөг.

Аюулгүйн үзлэгийн ажилтнуудыг үнэмлэхжүүлэх болон зааварлагчийг үнэмлэхжүүлэх талаар тус тус танилцуулсан. Мөн шинэ тоног төхөөрөмж, шинэ журам нэвтрүүлэх, аюулгүйн үзлэгийн цэг болон тээштэй холбоотой шинэ заналхийлэл үүссэн тохиолдолд 3 цагийн давтан сургалтыг зохион байгуулдаг байна.

Аюулгүйн үзлэгийн ажилтны үнэмлэх нь нэг жилийн хугацаатай бөгөөд хяналтын хуудас ашиглан ажилтны дадлага, чадамжийг үнэлж үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгадаг.

Дээрх сургалтуудаас гадна аюулгүйн үзлэгийн ажилтан нь холбогдох мэдээллийн сургалт /remedial, just-in-time, read-remind training/-уудад хамрагддаг байна.

Тээврийн аюулгүй байдлын ажилтныг бэлтгэх зааварлагчийг бэлтгэхдээ 40 цагийн сургалтад хамруулж амжилттай төссөн зааварлагчийг мэргэшүүлэх чиглэлээр хичээл заалгах, менторын доор ажиллуулах ба Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргааны маягыг ашиглан Чанарын үнэлгээ хийж, бүртгэл авснаар тухайн зааварлагч холбогдох чиглэлээр хичээл заах эрхтэй, гэрчилгээтэй багш болох журмыг үндэслэн зааварлагч нарыг бэлтгэж байна. Зааварлагчийн гэрчилгээ нь 5 жилийн хугацаатай ба дахин үнэлгээнд хамруулж хугацааг сунгагддаг байна.

2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

Тус өдөр Лас Вегас хотын Харри Рэйд олон улсын нисэх буудал дахь Дэвшилтэт аюулгүйн үзлэгийн цэг- Өөртөө үйлчлэх аюулгүйн үзлэгийн цэгтэй танилцах аяллыг зохион байгуулсан.

Нисэх буудал дээр аюулгүйн үзлэгийн ажилтнуудыг бэлтгэх, дадлага хийлгэх үзлэгийн цэг /TSA Academy West Training Checkpoint/-ийг байгуулж сургалт явуулдаг байна. Мөн тус нисэх буудлын зорчигчийн аюулгүйн үзлэгийн цэг дэх сүүлийн үеийн дэвшилтэд тоног төхөөрөмж болон TSA PreCheck үзлэгийн цэгийн зохион байгуулалтыг танилцуулсан болно. Энэхүү үзлэгийн цэгийн давуу тал нь дараалал удаан хүлээхгүй, зорчигчийн гутал тайлуулахгүй, баримт бичгийн шалгалтыг 5 минутад хийх онцлогтой ба Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаанаас 200 нисэх буудалд хэрэгжүүлээд байгаа юм.

Мөн тухайн өдөр Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас “Нисэхийн аюулгүйн байдлын соёл” тогтоох талаар болон тус байгууллагын цахим хаяг дахь мэдээллийг хэрхэн ашиглах тухай товч мэдээлэл өгсөн.

Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаа нь Нисэх буудлуудын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд тус байгууллага Филиппин Улсын Манила нисэх буудалтай 2019 оноос хамтран ажиллаж байгаа талаар танилцуулга хийсэн. Цар тахлын үед 2019-2021 онуудад онлайн уулзалтуудыг зохион байгуулж байсан ба 2023 онд Филиппин Улсын Тээврийн аюулгүй байдлын газар болон Манила нисэх буудлын төлөөлөгч нар Индианаполис нисэх буудалтай очиж танилцсан байна. Энэхүү хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаанаас зохих сургалтуудыг зохион байгуулж 2 байгууллагаас холбогдох мэргэжлийн ажилтнуудыг солилцож туршлага судлах арга хэмжээ авсан болно. Тус 2 байгууллага нь 2024 онд удирдлагуудын уулзалтыг 2024 оны 8 дугаар сард зохион байгуулах, хяналт, заналхийллийг таних, хариу арга хэмжээ авах зэрэгт анхаарч холбогдох сургалтуудыг зохион байгуулах зэрэг ажлуудыг төлөвлөсөн талаар танилцуулсан.

Мөн тухайн өдөр “TSA Academy West” сургалтын байгууллагын үйл ажиллагааг танилцуулсан ба тухайн байгууллагад аюулгүйн үзлэгийн ажилтнууд, дасгалжуулагч /coach/, удирдах албан тушаалтнуудын сургалтыг зохион байгуулахаас гадна нисэхийн аюулгүй байдлын сорилт хийх багийг бэлтгэдэг. Мөн сургалтад Майкрософт компанитай хамтран AI систем ашигладаг болсон талаар танилцуулга хийсэн.

2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр

Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргааны Лас Вегас хот дахь үнэрч нохой сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцсан. АНУ нь Тэсрэх бодис илрүүлэх нохойн багийн үндэсний хөтөлбөртэй бөгөөд тус сургалтын төв нисэх буудалтай гэрээ байгуулан хамтран ажилладаг байна. Сургалтын төвийн үнэрч нохойг Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаа болон хүчний байгууллагууд хамтран ашигладаг боловч нохой, нохой хөтлөгчийн сургалтыг энэхүү төвд зохион байгуулдаг. Тус төв нь нохой сонгон авах, малын эмнэлэгт үзүүлэх, сургах зэргийг хариуцдаг ба Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаанаас гэнэтийн хяналт шалгалт болон шалгалт хийдэг. Үнэрч нохойны сургалтад бодит тэсрэх бодистой ижил боловч өөрсдийн хийсэн сургалтын хэрэгслийг ашигладаг байна. Үнэрч нохойг зорчигчийн тээш, нисэх буудлын нийтийн эзэмшлийн бүс, хориотой бүсүүдэд ашиглах ба шаардлагатай тохиолдолд ачаанд үзлэг хийгдэг байна, ингэхдээ нисэх буудалтай байгуулсан тодорхой тусгадаг.

Үр дүн:

АНУ-ын Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаанаас зохион байгуулсан “Олон улсын сургалтын Симпозиум”-д оролцсоноор тус улсын нисэхийн аюулгүй байдлыг хангах арга хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, ялангуяа аюулгүйн үзлэгийн ажилтныг бэлтгэх сургалт, тэдгээрт тавигдах шаардлага, аюулгүйн үзлэгийн ажилтан нь албан тушаал дэвших, зааварчлагч бэлтгэх журам, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлага, дотоод эрсдэл, дэвшилтэд аюулгүйн үзлэгийн тоног төхөөрөмжтэй танилцаж, тус хуралд оролцсон олон улсын туршлагыг сонслоо.

Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргааны Бээжин дэх төлөөлөгчид Монгол Улсад тус байгууллагаас Агаараас эсэргүүцэн хамгаалах зөөврийн системийн эрсдэлийн үнэлгээ, Эрсдэлийн үнэлгээний семинар, Дотоод эрсдэлийн семинар, Зан байдлаар таних семинар болон Сонгон, тааварлашгүй байдлаар аюулгүйн үзлэг хийх сургалтуудыг зохион байгуулах боломж болон зохих баримт бичгийн хувийг авах талаар санал солилцлоо, тухайлбал Агаараас эсэргүүцэн хамгаалах зөөврийн системийн Үндэсний хөтөлбөр, зорчигчийн гутлыг тайлуулж рентген төхөөрөмжөөр шалгах журам, сонгон болон тааварлашгүй байдлаар аюулгүйн үзлэг хийх журам гэх мэт.


ТАНИЛЦСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА



Г.БАТБАЯР

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН
УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ



Ц.БАТ

ХЯНАСАН:

АЭРОДРОМ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
АХЛАХ БАЙЦААГЧ



Г.МӨНХБОЛД
vi/21

ТАЙЛАН БИЧСЭН:

АЭРОДРОМ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН НИСЭХИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ БАЙЦААГЧ



Б.АНХБАЯР